



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 19 өдөр

Дугаар A/359

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Үнэлгээний хорооны 2023 оны 07 дугаар сарын 05-ны 01 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумдын эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх сонгон шалгаруулалтаар шалгарсан компаниудыг хавсралтаар баталсугай.

2.Тендерт шалгарсан компаниудтай эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээ байгуулах эрхийг Эрүүл мэндийн газрын дарга (П.Оюунцэцэг)-т олгосугай.

3.Эм, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлтэд чанарын болон хугацааны хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

0323010591